



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/40

Мандатговь

Аймгийн хүүхдийн 12-р чуулган
зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 18 дугаар зүйлийн 18.2.1, "Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн 3-р зорилтын 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн хүүхдийн санаа бодлыг сонсох, хүүхдийн төлөө хийж буй ажлуудыг хүүхдийн нүдээр харах, үнэлэх, хүүхэд хөгжих, оролцоход тулгардаг асуудал, шийдэх арга замыг бодлого шийдвэрт тусгуулах, хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлэх зорилгоор "Аймгийн хүүхдийн 12 дугаар цахим чуулган"-ыг 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсугай.

2. Аймгийн хүүхдийн цахим чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, хөтөлбөрийг 3 дугаар, шаардагдах төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Чуулганд оролцох төлөөлөгч хүүхдүүдийг сонгох, цахимаар оролцоход нь арга зүйн дэмжлэг үзүүлэх, сумдын сургууль, орон нутгийн удирдлагуудтай холбогдон удирдамж чиглэл өгөх, хүүхдүүдийн оролцоог бүрэн хангах, илтгэл, персентаци, мэдээллийг бэлтгэн ажиллахыг Хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг), Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн (Э.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаанд шаардагдах 481540 (Дөрвөн зуун наян нэгэн мянга таван зуун дөх) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

5. Чуулганы үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмжийг боловсруулан үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж ажиллахыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн (Э.Мөнхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190081

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
А/10 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



АЙМГИЙН ХҮҮХДИЙН 12-Р ЦАХИМ ЧУУЛГАНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Мөнхжаргал
Хүүхдийн хөгжил, оролцоо
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Цэцэг
Хүүхэд хамгааллын мэргэжилтэн

Гишүүд:

Т.Насандэлгэр
ЗХТ-ийн сургалт хариуцсан ажилтан

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 11/40 дугаар тушаалын 02 дүгээр хавсралт



“ОРОЛЦООД ХӨГЖЬЕ” АЙМГИЙН ХҮҮХДИЙН ЦАХИМ ЧУУЛГАНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго: Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн төлөө хийж буй ажлуудыг хүүхдийн нүдээр харж, үнэлүүлэх, тэдэнд тулгамдсан асуудлыг бодлого шийдвэрт тусгах, хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлэхэд оршино.

Чуулганы нэр: “Оролцоод хөгжье”

Хамрах хүрээ:

- Орон нутгийн 16 удирдлага,
- Аймгийн МСҮТөв, бүх сумын сургууль бүрээс 8 сурагч, нийт 160 сурагч
- Сургуулийн 21 нийгмийн ажилтан,
- Сум бүрийн 15 хүүхдийн элч нар хамрагдана.

Хугацаа: Эхлэх: 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 10:30-д эхлэнэ.
Дуусах: 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 13:10-д дуусна.

Зохион байгуулагчид:

- Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- БСУГ, ЕБСургуулиуд, нийгмийн ажилтан нар
- Аймгийн МСҮТөв

Удирдлага зохион байгуулалт:


- Чуулганд оролцох 8 сурагчийн бүртгэл, мэдээллийг ирүүлэх (овог, нэр, нас, хүйс, Регистрийн дугаар, анги, гишүүнлэл, нэмэлт тайлбар - Хөгжлийн бэрхшээлтэй эсэх)
- Чуулганд оролцогч сурагчдыг Нийгмийн ажилтнууд удирдлагаар ханган нэг газар бөөгнөрөл үүсгэхгүй байгаа газраасаа цахимаар оролцоно. (Хавсралтаар явуулах хүснэгтийн дагуу оролцогчдын мэдээллийг 4-р сарын 30-ний өдрийн дотор мэргэжилтэн Э.Мөнхжаргалын egp.e-mongolia.mn хаягаар ирүүлнэ үү)
- Сургууль бүрээс оролцох 8 сурагчийг Нийгмийн ажилтан 8 сурагчийг бүртгэсэн Facebook-ын чат групп нээнэ.
 - ZOOM аппликэйшн утсандаа суулгаж бэлтгэх
 - ZOOM холбох интернет бүрдүүлж, шалгаж тохируулсан байх
 - Чуулганыг 2 цагаас хэтрэхгүй байхаар зохион байгуулж, сургууль бүрийн хүүхдийн саналыг хүлээн авч хүүхэд бүрийг сонсохыг чухалчилна
 - Төлөөлөгч сурагчдыг сонгохдоо СОУЗ-ын, ХОУЗ-ын, хөгжлийн бэрхшээлтэй, эрсдэлт нөхцөлд амьдарч буй, уралдаан тэмцээнд оролцогч хүүхэд, сүм хийдэд шавилан суудаг хүүхэд, оролцоог нь дэмжих шаардлагатай хүүхдийн төлөөллийг харгалзан оролцогчдын хүйсийн харьцаа тэгш байх хэрэгтэй.
 - 12 жилийн сургалттай сургууль бол 12, 11, 10, 9-р ангийн хүүхдүүдийн төлөөлөл, 9-н жилийн сургалттай сургууль бол 9, 8,7, 6-р ангийн хүүхдүүдийн төлөөлөл
 - Төлөөлөгч сурагчид санаа бодлоо 2-3 минутад багтаан илэрхийлэх (Урьдчилан саналаа бэлтгэн, цаг баримталж оролцох)
 - Сайн туршлагаа хуваалцахад бэлтгэлтэй байх (Урьдчилан сайн туршлагаа бэлтгэж оролцох)

Үр дүн:

- Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр тулгамдаж байгаа асуудлууд, санал санаачилгыг салбар бүрийн бодлого, төлөвлөлтөд тусган, хэрэгжүүлэх, хүүхдийн оролцох эрхийн хэрэгжилтийг сайжруулна.
- Хүүхдийн оролцоог бодитоор дэмжих арга замыг тодорхойлох
- Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаа эрчимжих
- Хүүхдийг нэг дор олноор сонсох цахим аргыг хэвшүүлэх

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн
А/М дугаар тушаалын 04 дүгээр хавсралт



**АЙМГИЙН ХҮҮХДИЙН 12-Р ЦАХИМ ЧУУЛГАН
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Хэрэглэгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Нэгж	Хүүхэд	135	2,000	270,000
2	Zoom эрх худалдан авах	Эрх	500	211,540	211,540
Нийт					481,540

-----oOo-----